БАТЛАВ
"ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨҮГ-ЫН
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР
Т.БАТМӨНХ
2025 оны 11 сарын 12 өдөр

ШИНЭ ХАЯГДЛЫН САН БАРЬЖ, БАЙГУУЛАХ ТАЛБАЙН МАЛТЛАГА, СУДАЛГААНЫ АЖЛЫН ТЕХНИКИЙН ДААЛГАВАР

ТАНИЛЦСАН:

ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНИКИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА — П.БАТБОЛОР

ХЯНАСАН:

БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ХЯНАЛТ, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА — Д.БАТБАЯР

БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ДАРГА — М.ОТГОН

БОЛОВСРУУЛСАН:

ГЕОЛОГИ, МАРКШЕЙДЕРИЙН ХЭЛТСИЙН ТЭРГҮҮЛЭХ ГЕОЛОГИЧ — Д.БАТТӨМӨР

Орхон аймаг, 2025 он

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	
1.1 Захиалагч байгууллагын нэр, хаяг.	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, Монгол улс, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Найрамдал талбай
1.2 Ажлын нэр.	Шинэ хаягдлын сан барьж, байгуулах талбайн малтлага, судалгааны ажил
1.3 Ажил гүйцэтгэх үндэслэл.	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Баяжуулах үйлдвэрийн шинэ хаягдлын аж ахуйн усан хураагуурын сангийн талбайн археологийн хайгуулын судалгааны ажлаар бүртгэгдсэн булш, хиргисүүр зэргийг авран хамгаалах,
1.4 Гүйцэтгэх ажлын иж бүрдэл	i. Судалгааны ажлыг Монгол улсын нутагт археологийн малтлага судалгааг хийх журмын дагуу, салбарын шинжлэх ухааны үндэстэй арга зүйгээр гүйцэтгэнэ. ii. Ажил гүйцэтгэх хээрийн судалгаа шинжилгээний ажлын календарьчилсан хуваарь, төлөвлөгөөг бэлтгэн захиалагчид танилцуулан батлуулах, iii. Авран хамгаалах археологийн судалгааны бэлтгэл ажлыг хангах (архивын судалгаа, зураглал, зөвшөөрөл авах) iv. Судалгааны газар дээр хээрийн судалгаа хийх: v. Газар дээрх судалгааны ажлууд (гадаргын тандан шинжилгээ, малтлага, шинжилгээний сорьц авах) vi. Илрүүлсэн археологийн дурсгалуудын байрлал, хэмжээс, давхарга зүйн мэдээллийг бүртгэх vii. Дурсгалуудыг баримтжуулах (зураг, дрон зураг, орон зайн мэдээлэл, 3D загвар зэрэг) viii. Олдворыг устгахгүйгээр авран хамгаалах арга хэмжээ авах ix. Судалгааны үр дүнг дүгнэх, тайлагнах x. Судалгааны эцсийн үр дүнг тайлан болгон боловсруулж, холбогдох байгууллагад хүлээлгэн өгөх, xi. Судалгааны явцад илэрсэн түүх, соёлын дурсгалт зүйлийн нас, гарал үүслийг тогтоох хожмын шинжилгээний үр дүнг гарсан даруйд захиалагчид хүргүүлнэ.
2. ТАВИГДАХ ШААРДЛАГА	
2.1 Чадвар.	i. ШУА-ийн Археологийн хүрээлэн нь Монгол улсад археологийн судалгаа хийдэг эрх бүхий байгууллага бөгөөд тус хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнууд бүгд мэргэжлийн сургууль төгссөн

	мэргэшсэн ажилтнууд байдаг бөгөөд магистрын зэргээс дээш зэрэгтэй ажилчид байна. ii. Археологийн мэргэжлийн баг бүрдүүлэх (түүх, археологи, антропологи, зураглалын мэргэжилтнүүд) iii. Туршлагатай ахлах археологич, судалгааны удирдагчтай байх iv. Соёлын өвийн судалгаа, хамгаалалтын ажлын туршлагатай байх v. Геодези, GIS хэрэглээний чадвартай байх vi. Тайлан боловсруулах, бичиг баримт бүрдүүлэх чадвартай байх
2.2 Техникийн шаардлага.	Гүйцэтгэгч нь Археологийн малтлага судалгааг ямар нэг машин техник хэрэглэхгүй ба зөвхөн гар аргаар малтлага судалгааг хийнэ. Техникийн шаардлагуудыг дор хаяж заавал хангасан байх ба тухайн ажлын онцлог эсвэл захиалагч нь шаардлагатай тохиолдолд харилцан зөвшилцсөний үндсэн дээр нэмэлт өөрчлөлт оруулж болно. i. Археологийн судалгааны багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан байх (GPS, нийт станц, дрон, металл илрүүлэгч, камер, хэмжих хэрэгсэл г.м.) ii. Талбайн судалгаанд шаардлагатай тээврийн хэрэгсэл, хээрийн баазын боломжтой байх iii. Лабораторийн шинжилгээний дүн гаргах чадамжтай байх буюу холбогдох лабораторитой хамтран ажиллах нөхцөлтэй байх байх,
2.3 Арга, аргачлал.	Судалгааны талбайн дурсгалуудаас 2025 онд нийт 50 дурсгалуудыг төрлөөр авч үзвэл хиргисүүр 27, дөрвөлжин булш 2, хүннү булш 5, тахилын байгууламж 6, Монгол булш 8, дугуй дарааст булш 1, сүм хийдийн туурь 1 өртөж байна. Эдгээр дурсгалуудын дийлэнх хувийг булш, хиргисүүр эзэлж байгаа ба археологийн малтлага судалгааны арга зүй нь доорх зарчмаар явагдана. Үүнд: i. Тухайн дурсгалын эхний баримтжуулалтыг хийх ii. Малтлагын талбай сонгож, байгуулах iii. Хөрсийг хуулах (10-20 см зузаан) iv. Багсаар цэвэрлэх v. Гэрэл зураг авах vi. Гар зураг зурах

	vii. Илэрсэн олдворын нивелерээр хэмжиж тэмдэглэх viii. Үргэлжлүүлэх дээрх зарчмын дагуу доош малтах ix. Илэрсэн олдворуудыг цэвэрлэж, хадгалалтын аюулгүй байдлыг хангах x. Тодорхойлолт бичих xi. Малтлага дууссаны дараагаар буцаан булах, баримтжуулалт хийх гэх мэт шат дараалалтай явагдана.
2.4 Бусад.	i. Судалгааны явцад үе шаттай хяналт тавих (ажлын явцын тайлан, фото баримт, газар дээрх үзлэг) ii. Ашигласан арга зүй, баримтжуулалтын стандартын хяналт iii. Археологийн дурсгалуудыг устгах, эвдэхгүй байх нөхцөл хангаж буй эсэх iv. Захиалагч болон Соёлын өвийн үндэсний төв, соёлын асуудал эрхэлсэн төрийн байгууллагаас томилогдсон хяналтын баг судалгааны явцад газар дээр ажиллах эрхтэй
3. АЖЛЫН ХЯНАЛТ, ТАЙЛАН БАРИМТ	
3.1 Ажлын хяналт, шалгалт.	Гэрээт ажлын гүйцэтгэлд захиалагч талаас хүлээн зөвшөөрч баталсан календарчилсан төлөвлөгөө, холбогдох гэрээ болон техникийн даалгаварт заасны дагуу хяналтыг тавина. Захиалагч нь шаардлагатай үед хэдийд ч гүйцэтгэгчийн хээрийн ажилтай танилцах эрхтэй ба ажлын гүйцэтгэлтэй холбоотойгоор нэмэлт мэдээ мэдээлэл гаргуулж авах эрхтэй. Захиалагчийн талын хяналт, шалгалт явуулах бүх нөхцөлийг гүйцэтгэгч саадгүй хангана
3.2 Тайлан боловсруулалт, материал хүлээлгэн өгөх.	Гүйцэтгэгч нь дараах байдлаар тайлан болон холбогдох мэдээллүүдийг боловсруулж захиалагч талд хүлээлгэн өгөх ба шаардлагатай тохиолдолд талууд харилцан зөвшилцөж тохиролцоно. Урьдчилсан байдлаар дараах шаардлагуудыг тавьж байна. Үүнд: i. Археологийн судалгааны нэгдсэн тайлан (түүхэн дүгнэлт, зураглал, олдворын бүртгэл, зураг) ii. GIS мэдээллийн багц iii. Бүх баримт цахим хэлбэрээр (PDF, shapefile, зураг) болон хэвлэмэл байдлаар бүрдүүлсэн байх iv. Шаардлагатай нэмэлт мэдээлэл, тайлангийн агуулгын өөрчлөлт зэргийг захиалагч тал гүйцэтгэгчээс шууд шаардах эрхтэй.

4. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА	
4.1. Ажил эхлэх.	Тухайн ажлын хамрах хүрээ ажлын нийт хэмжээ зэргээс шалтгаалан захиалагч болон гүйцэтгэгч талууд харилцан зөвшилцөж баталсан календарчилсан төлөвлөгөөний дагуу ажил гүйцэтгэх гэрээ байгуулснаар ажил эхэлнэ.
4.2. Хугацаа.	Гүйцэтгэгч нь ажил эхлэхийн өмнө өмнөх судалгааны материалтай ажиллах, бүх шатны дээжлэлтийн ажлуудыг гүйцэтгэж буй процедуртай танилцсанаар ажлын нарийвчилсан төлөвлөгөө боловсруулж, Захиалагчаар батлуулснаар ажлыг эхлүүлнэ. Уг төлөвлөгөөний календарчилсан төлөвлөгөөний дагуу ажил гүйцэтгэх хугацааг тогтоно.

ГМХ-ийн тэргүүлэх геологич Д.Баттөмөр